



“УЛААНБААТАР ХОТЫН МУЗЕЙ” НӨТӨ
ЗАХИРЛЫН ТУШААЛ

2024 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

“Гэр үзэсгэлэн” зохион байгуулах
ажлын төлөвлөгөө, хуваарь батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.5 дахь заалт, Монгол Улсын Соёлын сайдын 2024 оны 02 дугаар сарын 09-ны өдрийн “Үзэсгэлэн зохион байгуулах тухай” А/52 дугаар тушаал, Музейн хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.4.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Соёлын сэргэлт-2024 аян, Монгол улсад орчин цагийн музей үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Улаанбаатар хотын музейгээс зохион байгуулах “Гэр үзэсгэлэн”-ийн ажлын төлөвлөгөөг нэгдүгээр хавсралтаар, ажиллах хуваарийг хоёрдугаар хавсралтаар баталсугай

2. Амралтын өдрүүдэд ажилласан албан хаагчдад холбогдох хууль, журмын дагуу илүү цагийн хөлсийг тооцож олгохыг ахлах нягтлан бодогч (Ж.Мөнхтуяа)-д зөвшөөрсүгэй.

3.Төлөвлөгөөт арга хэмжээнд хяналт тавьж ажиллахыг менежер (Б.Нарангэрэл)-д үүрэг болгосугай.

ЗАХИРАЛ



П.ДАВААСҮРЭН

Музейн захирлын 2024 оны 05.
дугаар сарын 01-ны өдрийн А/18
дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



"ГЭР ҮЗЭСГЭЛЭН"-ИЙН НЭГДСЭН ХӨТӨЛБӨРИЙН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

2024 оны 05 дугаар сарын 01

Улаанбаатар хот

Д/д	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах ажилтан	Огноо	Тайлбар
1	2	3	4	5
1.	"Монгол гэр" үзэсгэлэнд оролцох ажлын төлөвлөгөө боловсруулан батлуулах	Б.Нарангэрэл Б.Өлзийбаяр	2024.04.30- 05.01	
2.	<p>Нийслэл өргөөнд зохион байгуулах боловсролын хөтөлбөрүүд:</p> <p>1. "Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал" Агуулга: Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгалын талаар ерөнхий мэдээлэл өгч ярилцах, Улаанбаатар хот дахь тангтай хөшөө, Сүхбаатарын хөшөө, Улаанбаатар хотын музей, Цирк зэрэг барилга, хөшөөний талаарх мэдээллүүдийг өгч ярилцана.</p> <p>2. "Төсөөллөө бүтээе" Улаанбаатар хотын үүсэл Агуулга: Улаанбаатар хотын 4 үеийн түүхийг тайлбарласан "Марчаахай" контентыг үзүүлнэ. Нийслэл хүрээний үеийн талаарх ерөнхий мэдээллийг өгч ярилцана.</p> <p>3. "Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал" леги хөтөлбөр (төлбөртэй) Агуулга: Улаанбаатар хот дахь түүхийг сонирхолтой хэлбэрээр танин мэдүүлэх, Леги барилга доторх барилгын түүхийг уншин танилцаж, эвлүүлж дуусаад бусдадаа танилцуулан мэдлэгээ бататган ярилцана.</p> <p>4. "Улаанбаатар хотын үл хөдлөх дурсгал" баримал хөтөлбөр (төлбөртэй) Агуулга: Улаанбаатар хот дахь түүхийг сонирхолтой хэлбэрээр танин мэдүүлэх, Богдын хүрээ буюу хуучин хотын үед хамаарах үл хөдлөх дурсгал "Улаанбаатар хотын музей" барилгыг хэвд цутган гарган авч будна.</p>	Батлагдсан хуваарийн дагуу тухайн өдөр ажиллах ажилтнууд	2024.05.4-12	

3.	"Улаанбаатар хот"-ын түүхийг харуулсан 34 ширхэг хэвлэмэл гэрэл зургийн бэсрэг үзэсгэлэнг бэлтгэн гэрийн хананд өлгөх, үзэсгэлэнгийн үзэгчдэд тайлбараар үйлчлэх	Батлагдсан хуваарийн дагуу тухайн өдөр ажиллах ажилтнууд	2024.05.4-12	
4.	"Хотын түүхийг 2 минутад" "Марчаахай" контентийг музейн гэрт ТВ-гээр тогтмол сурталчлах	Батлагдсан хуваарийн дагуу тухайн өдөр ажиллах ажилтнууд	2024.05.4-12	
5.	Музейгээс эрхлэн гаргасан соёлын бүтээлч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн (хөлөгт тоглоом, эвлүүлдэг зураг, буддаг ном, хүрээ ном, бусад материал)-ийг бэлтгэн авч явах	О.Алтантүлхүүр, Батлагдсан хуваарийн дагуу тухайн өдөр ажиллах ажилтнууд	2024.05.4-12	
6.	Үзэгчдэд музейн хэвлэмэл танилцуулга тараах, сурталчлах	Батлагдсан хуваарийн дагуу тухайн өдөр ажиллах ажилтнууд	2024.05.4-12	
7.	Үйл ажиллагаанд ашиглагдах туслах хэрэглэгдэхүүнийг бэлтгэх, тээвэрлэх, байршуулах, буцаан тээвэрлэх (жагсаалтын дагуу)	Батлагдсан хуваарийн дагуу тухайн өдөр ажиллах ажилтнууд	2024.05.4-12	
8.	Үйл ажиллагаанд оролцогчийн тоон дүнг бэлтгэсэн хүснэгтийн дагуу насны ангиллаар өдөр бүр авах, үйл ажиллагаанд оролцогч үзэгчийн гэрэл зургийг тогтмол авах	Батлагдсан хуваарийн дагуу тухайн өдөр	2024.05.4-15	


		ажиллах ажилтнууд		
9.	Үйл ажиллагааны гэрэл зураг, тоон мэдээ, төсөв зэргийг нэгтгэн нэгдсэн тайлан гаргаж хариуцагч байгууллагад илгээх	Б.Өлзийбаяр	2024.05.4-15	
10.	Үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг байгууллагын цахим хуудас, бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэлж түгээх	С.Эрдэнэбат	2024.05.4-15	

Цагийн хуваар: 2024 оны 05 дугаар сарын 04-өөс 12-ны өдрүүдэд

Даваа - баасан гарагт: 10:00-18:00 цагт

Бямба - ням гарагт: 10:00-20:00 цагт

Музейн захирлын 2024 оны 05.
дугаар сарын 01 -ны өдрийн А/Б
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



"ГЭР ҮЗЭСГЭЛЭН" АРГА ХЭМЖЭЭНД АЖИЛЛАХ ХУВААРЬ

2024 оны 5 дугаар сарын 03

Д/д	Ажилтны нэрс	Албан тушаал	2024 .05.04 Бямба	2024.05.05 Ням	2024 .05.06 Даваа	2024 .05.07 Мягмар	2024 .05.08 Лхагва	2024 .05.09 Пүрэв	2024 .05.10 Баасан	2024 .05.11 Бямба	2024 .05.12 Ням
1.	Ч.Өсөхжаргал	Бүртгэл мэдээллийн санч	10 цаг ✓								
2.	Л.Одмаа	Боловсролын ажилтан	10 цаг ✓							2 цаг ✓	
3.	Б.Өлзийбаяр	Арга зүйч		10 цаг ✓							
4.	Б.Нарангэрэл	Менежер		10 цаг ✓							
5.	П.Ариунаа	Сан хөмрөгч									
6.	Д.Дэлгэрмөрөн	Тайлбарлагч									10 цаг ✓
7.	О.Одсүрэн	ЭША								10 цаг ✓	
8.	Г.Очбаяр	ЭША									
9.	С.Эрдэнэбат	Дизайнер									10 цаг ✓